



Бурхан бол бидний итгэлтэй байдал Залбирлын Хуудас Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол бидний итгэлтэй байдал **Attribute: God Is Our Confidence**

Тодорхойлолт: Бидний итгэдэг, найддаг, итгэл найдвараа тавьдаг Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Дуулал 71:5** Учир нь Та миний найдвар БУРХАН Эзэн, Та бол залуугаас минь миний итгэл юм.
- **Сургаалт үгс 3:26** ЭЗЭН чамд эр зориг болж Хөлийг чинь занганд баригдахаас хамгаална.
- **1 Иохан 5:14-15** Бид Түүний хүслийн дагуу юу ч гүйсэн, Тэр биднийг сонсдог нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. Бид юу ч гүйсэн, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гүйснаа авсан болохоо мэднэ.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Еврей 10:35-36

Библийн эшлэлээр залбирах:

Тиймд агуу шагнал бүхий итгэлээ хаяхыг (Хүүхдийн нэр)-д бүү зөвшөөрөөч. (Хүүхдийн нэр) Танаас шагналыг элбэгээр хүлээн авах болтугай. (Хүүхдийн нэр) тэвчээртэй байж Бурханы хүслийг биелүүлээд амлагдсаныг хүлээж авах болтугай.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- Тиймд агуу шагнал бүхий итгэлээ хаяхыг _____-д бүү зөвшөөрөөч. _____Танаас шагналыг элбэгээр хүлээн авах болтугай. _____ тэвчээртэй байж Бурханы хүслийг биелүүлээд амлагдсаныг хүлээж авах болтугай. *Еврей 10:35-36*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!